

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.2, 60.1, 60.2-д заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Дархан Гурил Тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 12 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж, Твин тауер 2/307 танхимд зарлан хуралдуулахаар тогтсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- i). Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
- ii). Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- iii). Зохион байгуулалтын асуудал.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дугаар сарын 11 -ний өдрөөр тогтоосугай.

4. 2022 оны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын үндэслэлийн талаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ш.Энхтөр)-т үүрэг болгосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй. Хурлын зар мэдээг анхны мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа өдөр тутмын нэг сонинд, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгнээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтад заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Дархан уул аймаг, Дархан сум, 1-р баг, “Дархан Гурил Тэжээл” ХК -н өөрийн байранд ирж танилцаж болохыг дурдсугай.